

**УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА
БУСАД ИЖИЛ ТӨСТЭЙ БАРИМТ БИЧГИЙГ УУЛ УУРХАЙН
ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХАД
АШИГЛАХ ТУХАЙ**

**ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛД ТУСЛАЛЦАА
ҮЗҮҮЛЭХ ТӨСӨЛ**

Эс Жи Геммелл

2020 оны 9 дүгээр сарын 18

Мэдэгдэл

Энэхүү тайлан, илтгэлийг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газар бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Мөн түүнчлэн энэ тайланд тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ тайланд багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй. Энэхүү хэвлэлд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

Адам Смит Интернэшнл олон улсын байгууллага нь Австрали Улсын Засгийн газрын санхүүжилтээр Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП)-ийг хэрэгжүүлж байна.

Adam Smith
International

Цар хүрээ

Уул уурхайн ирээдүйн үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох төрийн байгууллагад тайлагнахад Монгол Улсаас бусад улсад ашигладаг баримт бичгийн талаар судалгаа хийх даалгаврыг АМЭБСХАХ (Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр) авсан.

Одоогийн нөхцөл байдал Монгол Улсад ямар байгааг АМЭБСХАХ дараах байдлаар ойлгож байгаа болно. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөвшөөрлийг авснаас хойш нэг жилийн дотор Техник, эдийн засгийн үндэслэлийг (журмаар тодорхойлсны дагуу) боловсруулж, хүргүүлэх үүрэгтэй. Хүргүүлсэн техник, эдийн засгийн үндэслэлийг төлөвлөсөн үйл ажиллагааны аюулгүй, тогтвортой байдал, эдийн засгийн нөлөө, ирээдүйд үзүүлэх дэд бүтцийн дэмжлэг болон бусад ажлыг үнэлж тодорхойлох зорилгоор төрийн байгууллагууд ашигладаг байна. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэлийг тогтмол буюу (i) тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөнөөр; (ii) үйл ажиллагаа явуулаагүй 3 жил өнгөрснөөр болон (iii) анхны техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авснаас хойш 5 жил тутамд шинэчлэхийг шаарддаг.

Хөгжингүй болон хөгжиж буй олон улсад ихэнхдээ техник, эдийн засгийн үндэслэлийг санхүүжүүлэлт татах зорилгоор ашигладаг бөгөөд төрд мэдээлэл өгөх зорилгоор ашигладаггүй. Канад, Австрали зэрэг зарим улсад төслийг санхүүжүүлэхээс өмнө NI 43-101 маягт бүхий тайлангаар болон хөрөнгийн биржийн мэдээгээр техник, эдийн засгийн үндэслэлийн хураангуй мэдээллийг нийтэд дэлгэдэг ба төрийн байгууллагууд тухайн нийтэд түгээсэн мэдээлэлтэй танилцах боломжтой байдаг. Гэвч олон нийтэд ч, төрд ч тайланг бүтнээр нь өгдөггүй ба тайланд орсон дараа дараагийн өөрчлөлтүүдийг товч байдлаар л нийтэд мэдээлдэг байна. Иймд төрийн хяналт тавих этгээд үйл ажиллагаандаа шаардлагатай мэдээллийг тогтмол авах зорилгоор бусад механизмыг ашигладаг байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар Техник, эдийн засгийн үндэслэл хариуцсан ажлын хэсэг өргөн хүрээний төлөөлөлтэйгөөр байгуулагдаж, техник, эдийн засгийн үндэслэлийн мэдээлэлтэй ижил төстэй мэдээлэл гаргаж өгдөг бусад улс орнуудын туршлагын талаар зөвлөгөө хүссэн.

Энэхүү судалгаагаар Австрали ба Америкийн Нэгдсэн Улсын хэд хэдэнд муж улсад ирээдүйн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн зохицуулдгийг авч үзсэн ба тухайн төлөвлөгөөг “Хувилбар/ижил төстэй баримт бичиг” гэж дурдсан болно.

Нэмэлт шаардлага, хязгаарлалт

Ихэнх тохиолдолд хувилбар баримт бичиг нь хэд хэдэн төрийн байгууллагууд, тэр дундаа байгаль орчин ба хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын шаарддаг мэдээллийг агуулсан байдаг. Энэ тохиолдолд уул уурхайн зохицуулагч байгууллага нь тухайн баримт бичгийг хүлээж авч, шилжүүлэх төв байгууллага болдог байна. Ихэвчлэн байгаль орчинтой холбоотой төлөвлөлт, түүний үр дүн ижил төстэй баримт бичгийн томоохон хэсгийг бүрдүүлдэг боловч үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл чухал бүрэлдэхүүн хэвээр байдаг.

Энэхүү тайланд зөвхөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-аас шаардаж болохуйц баримт бичгийн талаар авч үзсэн болно.

Ихэнх хувилбар баримт бичигт санхүүгийн үр дүнг тоогоор илэрхийлдэггүй ба илэрхийлсэн тохиолдолд ихэнхдээ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн

тайлангийн хавсралтад, ирэх жилийн мэдээлэлд зориулж нууцлалтай байдлаар оруулдаг байна.

Хувилбар загварууд

Судалгааны дүнд уул уурхайн ирээдүйн үйл ажиллагааны төлөвлөгөөг маш олон янзаар шаарддаг болох нь тодорхой болсон. Улс орнуудын зохицуулалтын ялгаатай тал нь дараах асуудлаас хамааралтай байна:

- 1) Эдийн засаг, уул уурхайн хамаарлын түвшин. Уул уурхайн салбар нь харьцангуй хөгжсөн бөгөөд эдийн засагт нөлөөлөл өндөр бол хувилбар баримт бичиг нь энгийн байх хандлагатай байна.
- 2) Уул уурхайн салбарын хэмжээ.
- 3) Уул уурхайн бүсүүдэд газрыг бусад байдлаар ашиглах явдал. Газрыг бусад байдлаар ашиглах явдал түгээмэл бол хувирбар баримт бичиг илүү боловсронгуй байдаг. Энэ нь хувирбар баримт бичиг боловсруулан гаргах явц дахь гадны сонирхогч этгээдийн оролцооны түвшнээс хамаардаг.

Ирээдүйн үйл ажиллагааны талаар мэдээлэл гаргахыг шаарддаг хэд хэдэн улс орнуудад ашигладаг загварыг нарийвчлалын түвшин өсөх байдлаар нь дараах ерөнхий ангилалд хувааж болж байна.

- 1) Мэдээлэл тогтмол гаргахыг шаарддаггүй.
- 2) Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авах бүрд болон хугацаа сунгах бүрд уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө (УУҮАТ)-г шаарддаг.
- 3) Ирээдүйд хийх ажлын хөтөлбөрийг уул уурхайн жилийн тайланд тусгадаг.
- 4) Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтмол гаргахыг шаарддаг.

Загвар 1: Мэдээлэл тогтмол гаргахыг шаарддаггүй

Энэ тохиолдолд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө уул уурхайн төлөвлөгөөг гаргаж өгдөг. Дараа нь аливаа албан ёсны уул уурхайн төлөвлөгөөг шаарддаггүй.

Уурхайн талбай дахь одоогийн болон ирээдүйд хийгдэх ажлыг үнэлэхдээ уул уурхайн зохицуулагч байгууллага нь бусад арга механизмыг ашигладаг. Жишээлбэл (i) барилгын болон бусад зөвшөөрөл (үйл ажиллагааны хэмжээ, төрөл, ажилд хязгаарлалт тогтоож); ба (ii) уул уурхайн хяналтын байцаагчийн холбогдох хууль тогтоомжийн дагуух заавар даалгавар зэрэг.

Барилга, бүтээн байгуулалтын зөвшөөрлийг төслийн цар хүрээнээс хамаараад мужийн болон орон нутгийн төрийн байгууллагаас олгодог. Уурхайн талбай дахь дэд бүтцийн хэмжээ, байршил, газар шорооны ажил, барилга байгууламжийн төлөвлөгөө, цахилгааны суурилуулалт зэрэг төслийн тодорхой үзүүлэлтүүдийг тогтоодог. Үйл ажиллагааны хязгаарлалтуудыг (чимээ, тоос, бохирын хяналт, үйл ажиллагааны дэвсгэр зураг зэрэг) энэ үе шатанд тогтоодог. Австрали, Канадад уул уурхайн зохицуулагч төрийн байгууллага нь мужийн түвшинд байдаг бол Өмнөд Африк зэрэг улсуудад уул уурхайн зохицуулагч төрийн байгууллага нь үндэсний түвшинд байдаг гэдгийг анхаарах хэрэгтэй. АНУ-д уул уурхайн зохицуулагч төрийн байгууллага нь үндэсний түвшинд

байдаг боловч уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчийн тайланг авдаг эрх бүхий байгууллагууд Холбооны болон Мужийн байгууллагуудаар тарсан байдаг.

Практикт анх хүлээн авсан төлөвлөгөөгөөр тогтоосон үзүүлэлтэд дахин төлөвлөгөө гарган батлуулахгүйгээр өөрчлөлт оруулдаггүй. Хэдийгээр энэ загвар бусадтай нь харьцуулахад хязгаарлалт бага тогтоож байгаа мэт боловч төрөөс тавих хяналт сул биш байна.

Загвар 2: Тусгай зөвшөөрөл авах бүрд болон хугацаа сунгах бүрд уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг өгдөг

Төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдэхэд уул уурхайн төлөвлөгөө шаардлагатай болдог. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хүртэл төлөвлөгөө гаргаж өгөхийг дахин шаарддаггүй. Гэвч Загвар 1-тэй адилаар дахин төлөвлөгөө гаргалгүйгээр өөрчлөлт оруулж болохгүй.

Уул уурхайн төлөвлөгөөний үндсэн зорилго нь:

- Тусгай зөвшөөрөл бүхий талбайд ашигт малтмал олборлох болон бусад үйл ажиллагааны онцлог, цар хүрээний талаар зохицуулагч байгууллагад илүү ойлголт өгөх;
- Хийхээр төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажлыг үнэлэх, зохимжтой эсэхийг тодорхойлох (ашигт малтмал олборлож эхлээгүй, эсхүл тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд энэ нь онцгой ач холбогдолтой);
- Ашигт малтмалын ашиглалт, аливаа ариутгалын асуудлыг үнэлэх; болон
- Эрдэс баялгийн удирдлагын аливаа зохистой шийдвэр гаргахад ашиглах.

Уул уурхайн төлөвлөгөөний цар хүрээ

Уул уурхайн үйл ажиллагааны хэмжээ, нарийн төвөгтэй байдлаас уул уурхайн төлөвлөгөөний цар хүрээ шалтгаалдаг. Жишээлбэл шороон ордны алтны төсөл, жижиг ил уурхайн үйл ажиллагааны хувьд хэд хэдэн давхрага бүхий ил уурхай болон нүүрсний судлын хийн асуудалтай далд уурхайн үйл ажиллагаанаас бага мэдээлэл шаарддаг.

Төлөвлөгөөг ашиглалтын тусгай зөвшөөрөл бүрээр гаргадаг. Хэрвээ тусгай зөвшөөрөл нь бусад зөвшөөрөлтэй хамаатай, эсхүл төслийн нэг хэсгийг бүрдүүлж байвал төлөвлөгөөнд төслийг тайлбарлаж, энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрлийн хамаарлийг тодорхой харуулах ёстой.

Ихэвчлэн дараах агуулгатай байдаг:

- 1) Ашиглалтын тусгай зөвшөөрөл ба тусгай зөвшөөрөл эзэмшигчийн танилцуулга;
- 2) Тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа эхэлсэн, эсхүл эхлүүлэхээр төлөвлөсөн хугацаа;
- 3) Тусгай зөвшөөрлийн талбайд уул уурхайн бусад зөвшөөрөлтэй хамтаар төслийн нэг хэсэг болгож үйл ажиллагаа явуулж байгаа, эсхүл явуулахаар төлөвлөж байгаа эсэх мэдэгдэл (хэрвээ тийм бол төслийн мэдээллийг оруулах ба тухайн тусгай зөвшөөрөл төсөлтэй хэрхэн холбогдох талаар, мөн төсөл болон бусад зөвшөөрлийн хувьд яагаад энэ тусгай зөвшөөрөл шаардлагатай талаар оруулна)
- 4) Үйл ажиллагааны арга, аргачлалын тойм;
- 5) Уул уурхайн төлөвлөгөөнд шаардлагатай хавсралтууд; болон

- 6) Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд хүлээх үүргийг ойлгож байгаа ба бүх шаардлагатай мэдээллийг бүрэн тусгасан, мөн бусад этгээдийн оруулсан мэдээлэл нь бүрэн, үнэн зөв бөгөөд түүний зөвшөөрлийн дагуу оруулсан гэдгийг баталгаажуулсан өргөдөл гаргагчийн мэдэгдэл.

Дээрх 3 дахь хэсэгтэй холбоотойгоор төслийн хүрээг харуулсан газрын зургийг төлөвлөгөөнд оруулах ба бусад тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг тэмдэглэсэн байна.

Дээрх 4 дэх хэсэгтэй холбоотойгоор үйл ажиллагааны арга аргачлал нь:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлох эрхтэй бүх ашигт малтмалыг хамарсан байна;
- Цооног, овоолго, хаягдлын овоолго, боловсруулах байгууламж, хаягдал хадгалах байгууламж, дэд бүтэц зэрэг газар шорооны ажил, үе давхарга, байгууламжийн хэмжээ, хэлбэрт нийцэх арга аргачлалын талаар нарийвчлан тусгасан байх;
- Ашиглалтын зориулалтад нийцсэн эрдэс баялгийн нөөц болон уул уурхайн мэдээллийн хангалттай график дүрслэлтэй байх (жишээлбэл газрын зураг, гэрэл зураг, диаграм зэрэг);
- Тусгай зөвшөөрөл бүхий газарт барих, засах дэд бүтцийн талаар тайлбарлан оруулах;
- Нөхөн сэргээх ажлын арга аргачлалыг тайлбарлах; ба
- Энэхүү үйл ажиллагаанд шаардлагатай ажиллах хүчний талаарх мэдээллийг оруулах.

Дээрх 6 дахь хэсэгтэй холбоотойгоор гарын үсэг зурсан хүн бүрийн нэр, албан тушаал, гарын үсэг, огноог мэдэгдэлд дурдсан байна.

Энэхүү аргыг байгаль орчны асуудал эрхэлсэн зохицуулагч байгууллагад тусдаа үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтмол өгдөг газарт ихэвчлэн ашигладаг байна.

Загвар 3: Ирээдүйд хийх ажлын төлөвлөгөөг уул уурхайн жилийн тайланд тусгадаг

Энэхүү төлөвлөгөө нь мэдээллийн хувьд хязгаарлагдмал боловч бусад загвартай харьцуулахад илүү өргөн ашиглагддаг. Ихэвчлэн төрийн байгууллагад өгдөг үйл ажиллагааны жилийн тайланд, эсхүл ашигт малтмалын нөөц ашигласны тайланд (мөн жилийн давтамжтай) хавсралт болж болдог. Хэдийгээр ашиглалтын тусгай зөвшөөрлийн жилийн тайланг ирээдүйн ажлын төлөвлөгөөг авдаг бусад загваруудад ч мөн адил шаарддаг боловч ирээдүйд хийх ажлын талаар өөр баримт бичигт тусгадаг тул нарийвчилсан мэдээллийг шаарддаггүй байна.

Энэхүү загварын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаас өмнө уул уурхайн төлөвлөгөөг гаргаж өгдөг ба уул уурхайн төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгадаг:

- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд төлөвлөж байгаа ажлын мэдээлэл, бүтээн байгуулалтын үе шат,
- Олборлолтын аргачлалын нарийвчилсан мэдээлэл,
- Үйл ажиллагааны улмаас эвдэгдэх газрыг явцын дунд болон хугацааны эцэст нөхөн сэргээх ажлын мэдээлэл,
- Бүтээн байгуулалттай холбоотой геологийн болон байгаль орчны асуудлыг шийдвэрлэх менежментийн стратеги.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “уул уурхайн төлөвлөгөөний дагуу дараа жил хийх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г жилийн тайланд гаргаж өгөх ёстой. Мэдээж үүнийг ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө гаргаж өшсөн мэдээллээс гадна тусгай зөвшөөрлийн жилийн тайланд шаардлагатай өмнөх түүхэн мэдээлэлтэй хамааралтайгаар авч үзнэ. Өмнөх жилийн түүхэн мэдээлэлд ихэвчлэн дараах мэдээллийн хураангуйг тусгадаг:

- Худалдсан, эсхүл хадгалж буй бүтээгдэхүүний хэмжээ, үнэ цэн;
- Хүдэр болон хаягдлын хэмжээ, боловсруулсан хүдрийн хэмжээ;
- Олборлосон хүдэр, хаягдлын эх үүсвэр, зайлуулсан хаягдлын мэдээлэл;
- Барьж байгуулсан уурхайн бүтээн байгуулалт (хэрвээ бий бол);
- Технологийн үйл ажиллагааны дэвшил (хэрвээ бий бол);
- Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа;
- Олборлолт, хайгуулын үйл ажиллагааны зардал;
- Ажиллах хүчний мэдээлэл;
- Зохицуулагч байгууллагаас шаардсан тусгай зөвшөөрөлтэй талбайд хийх хайгуулын мэдээлэл;
- Ашигт малтмалын нөөцийн мэдээллийг хүдрийн орд бүрээр Австралазийн Хүдрийн Нөөцийн Хамтрсан Хорооноос гаргасан стандартын дагуу гаргасан байх.

Дээрх жагсаалтад дурдсан асуудлуудад хийх томоохон өөрчлөлтүүдийн мэдээллийг нарийвчлан гаргана. Түүнчлэн, дараах мэдээллийг нэмж шаарддаг:

- Тайлангийн үнэн зөвийн талаарх мэдэгдэл;
- Тайлант хугацаан дахь хайгуулын зардал;
- Хэрвээ боломжтой бол өрөмдлөг ба холбогдох газар зүйн шинжлэх ухааны мэдээллийн сангийн цахим хуулбар, геологийн онцлог шинж, эрдэсжилтийн зураглал, байр зүйн гадаргуйн загвар, нээлттэй цооног ба далд уурхайн ажлын (тулгуурыг оруулан) зураглал, уурхайн төлөвлөгөө (бүтээн байгуулалт болон нүүрний газрын зураг), хүдрийн биет блокын загвар болон эдгээрийн зохих мета-өгөгдөл;
- Хаягдал хадгалах байгууламж хаягдал чулууны овоолго зэрэг хаягдал хадгалах дэд бүтцийн бүтээн байгуулалт, засвар үйлчилгээний бусад холбогдох тайлан, төлөвлөгөөний мэдээлэл; ба
- Нөхөн сэргээлтийн үйл явц ба эцсийн нөхөн сэргээлтийн үйл ажиллалааны талаарх холбогдох тайлангийн мэдээлэл.

Энэхүү загварын дагуу гаргах мэдээлэл нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуустал нууцлалтай байх ба санхүүгийн мэдээллийг ерөнхийдөө нууцлалаас гаргадаггүй.

Загвар 4: Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтмол гаргадаг

Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хамгийн багадаа 3-5 жил тутамд тогтмол гаргадаг бөгөөд хэрвээ уурхайд үйл ажиллагаа явуулаагүй, эсхүл хаагдсан бол 7 жил тутамд гаргадаг байна. Төлөвлөгөөнд тусгасан мэдээлэлд (олборлолтын арга, боловруулах арга, хаягдал хадгалалт, хаягдал чулуу, хөрсний хадгалалт, бүтээгдэхүүн боловсруулах дэд бүтэц, үйлдвэрлэлийн хүчин чадал, өргөтгөл, цомхотгол, түр хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоох, хаах, эсхүл үйл ажиллагаагаа дахин явуулж эхлэх зэрэг) ямар нэг өөрчлөлт орохоос өмнө буюу төлөвлөгөөний аливаа чухал хэсэгт өөрчлөлт гарвал төлөвлөгөөг дахин гаргаж өгөх ёстой. Энэхүү үйл явцыг нарийн

зохицуулсан байдаг. Зарим тохиолдолд дараалан гаргасан уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөний хоорондох хугацаа богино буюу 6 сар байх ч тохиолдол байдаг.

Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах мэдээлэл

Төлөвлөгөөнд тусгах мэдээлэл янз бүр байдаг. Гэхдээ дор дурдсан жагсаалтад ихэнх тохиолдолд шаарддаг мэдээллийг оруулсан болно.

Энэхүү жагсаалтыг хэд хэдэн муж улсын жишээнээс бүрдүүлсэн бөгөөд жагсаалтад дурдсан бүх мэдээллийг агуулдаг уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө байхгүй гэдгийг анхааралдаа авна уу. Иймд уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөний зохих агуулгын жагсаалтыг гаргах гэж байгаа зохицуулагч байгууллага нь юуны түрүүнд жагсаалтыг ерөнхий байх (жишээлбэл Нью Саут Вэльс-тэй адил буюу шаардлагатай гэж үзсэн бүхий л мэдээллийг орсон эсэхийг баталгаажуулах үүргийг төлөвлөгөө гаргагч нь хүлээдэг), эсхүл тусгайлсан байх (жишээлбэл Өмнөд Австралитай адил) эсэхийг шийдэх хэрэгтэй.

Түүнчлэн энэхүү жагсаалтад байгаль орчны болон хяналт шалгалтын асуудлыг оруулаагүй гэдгийг анхаарна уу.

Нүүр хуудас

Ихэнхдээ нүүр хуудаст дараах мэдээлэл ордог:

- Уурхайн нэр
- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө эхлэх огноо
- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө дуусгавар болох огноо
- Ашигт малтмалын зөвшөөрөл (түрээс, тусгай зөвшөөрлийн дугаар)
- Зөвшөөрлийн нэр/ Зөвшөөрөл эзэмшигч(ид)
- Уурхайн үйл ажиллагаа эрхлэгч (хэрвээ тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өөр бол)
- Уурхайн менежер (эсхүл бусад төстэй этгээд)-ийн нэр, холбоо барих мэдээлэл
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төлөөлөгчийн нэр, холбоо барих мэдээлэл
- Зөвшөөрөл эзэмшигч(ид)-ийн төлөөлөгчийн нэр
- Зөвшөөрөл эзэмшигч(ид)-ийн төлөөлөгчийн албан тушаал
- Зөвшөөрөл эзэмшигч(ид)-ийн төлөөлөгчийн гарын үсэг
- Огноо
- Хувилбар

Дээр дурдсан төлөөлөгчийн мэдээлэл, гарын үсэг нь компанийн захирал, эсхүл компанийн нарийн бичгийн дарга байх ёстой.

Мэдэгдэл

Мэдэгдэл ихэвчлэн дараах агуулгатай байдаг:

“[Муж улсын нэр] мужын [хотын нэр] хотын [нэр] би дараах мэдэгдлийг үнэн зөвөөр гаргаж байна:

- 1) Би [төсөл] -ийн зохих ёсоор томилогдсон Үйл ажиллагаа хариуцсан менежер мөн болно;
- 2) Би [өргөдөл гаргагч]-ийн нэрийн өмнөөс энэхүү мэдэгдлийг гаргах зөвшөөрөл авсан болно;
- 3) Энэхүү мэдэгдлийг хавсаргасан Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бүхий л ажил, үйл ажиллагаа нь Уул уурхайн үйл ажиллагааны

төлөвлөгөөнд дурдсан ашиглалтын тусгай зөвшөөрөл(үүд)-ээр олгосон эрхийн нөхцөл болзлыг хангасан бөгөөд бүтээн байгуулалтын зөвшөөрөл, бусад төрийн байгууллагаас түүнтэй холбоотойгоор олгосон бүхий л зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн дагуу тавигдах шаардлагад нийцсэн болно.

- 4) Өмнөх догол мөрөнд дурдсан бүх ажил, үйл ажиллагаа нь Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан талбайн хэмжээнд бүрэн хамаарч байгаа бөгөөд тусгай зөвшөөрлийн (ашиглалтын лиценз, газар өмчлөл зэрэг) нарийвчилсан мэдээлэл зөв болохыг би баталж байна.

[Тангаргийн тухай хууль эсвэл түүнтэй адилтгах хууль тогтоомжид заасан хэлбэрээр гарын үсэг зурсан мэдэгдэл бичсэн байх] гэж мэдүүлсэн гэрчийг байлцуулан,

[Тангаргийн тухай хууль эсвэл түүнтэй адилтгах хууль тогтоомж] -ийн заалтын дагуу үнэн зөв гэдэгт итгэлтэйгээр энэхүү мэдэгдлийг би гаргаж байна.

Үйл ажиллагааны түүх

Өргөдөл гаргагч нь өмнөх үйл ажиллагааны товч түүх, өмнө нь ирүүлсэн Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө (УУҮАТ)-ний талаар мэдээлэх ёстой. Зорилго нь УУҮАТ-нд тохирсон нөхцөл байдлыг бүрдүүлэхэд хангалттай мэдээлэл өгөх явдал юм.

Одоогийн зөвшөөрөл, эрх олголт, тусгай зөвшөөрөл

Өргөдөл гаргагч нь хүснэгтэн хэлбэрээр ялгах тэмдэг, олгосон огноо, одоогийн зөвшөөрөл, бүрэн эрх, тусгай зөвшөөрлийн үргэлжлэх хугацааг дараахь байдлаар оруулах ёстой:

- Төсөл батлах / бүтээн байгуулалтын зөвшөөрөл
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл ба эрх олголт
- Хайгуулын зөвшөөрөл; болон
- Уул уурхайн үйл ажиллагааны талаар төрийн байгууллагуудаас олгосон бусад зөвшөөрөл, лицензүүд (байгаль орчны зөвшөөрөл, аюултай бодисын зөвшөөрөл гэх мэт).

Газар өмчлөх, газар ашиглах

Өргөдөл гаргагч нь зөвшөөрлийн талбайн дагуу газар өмчлөх, эзэмших эрх, өмчлөх хуваарийн зэрэгцээ ерөнхий талбайг хэрхэн эзэмшиж буй байдлын тоймыг өгөх ёстой. Бүх өмчлөлийг бичихдээ дараах байдлаар зөв тодорхойлсон байх ёстой: жишээлбэл, хувийн өмчлөл, хаант засгийн эзэмшлийн сул газар, цэцэрлэгт хүрээлэнгийн нөөц газар. Газар өмчлөгчдийг тодорхойлох шаардлагагүй.

Оролцогч этгээдүүдийн зөвлөлдөх уулзалт

Энэхүү мэдээлэл нь шаардлагатай бол өргөдөл гаргагч үүнийг хураангуйлах ёстой (i)

Төслийн тодорхойлолт

Уурхайн төслийг үйлдвэрлэлийн хэмжээ, уурхайн хүлээгдэж/таамаглагдаж буй ашиглалтын хугацааг оруулаад нэгтгэн дүгнэх хэрэгтэй. Уурхайн ашиглалтын хугацааны туршид уул уурхайн үйл ажиллагааны ерөнхий дараалал, үе шатыг тайлбарлах хэрэгтэй. Энэ мэдээлэлд дараахь орно:

- Ордын байршил, хэмжээ, орд газрын нээлт, хотгор, нугалаа (хэрэв мэдэгдэж байвал), жигд бус газар (хөрсний нуруулт, хагарал, карстын онцлог эсвэл геологийн нэгжийн зааг) зэрэг геологийн ерөнхий тодорхойлолт;
- Чулуулаг, элсний найрлага, үүнд хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй эрдэс бодисууд (жишээлбэл цацраг идэвхт ашигт малтмал, асбест);
- Хүдрийн найрлага;
- Хог хаягдал ба хог хаягдлын хувь хэмжээ, үүнд хүрээлэн буй орчныг бохирдуулж болзошгүй эрдэс бодисууд (жишээлбэл, хүчил үүсгэж болзошгүй сульфидын эрдэс бодисууд);
- Явуулсан хайгуулын ажлын тодорхойлолт, үр дүн;
- Уурхайн ам, ил уурхайн боомтноос олборлох, борлуулах стандарт барааны тодорхойлолт;
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь ашигт малтмал / Нүүрсний баялаг ба Хүдэр / Нүүрсний нөөцийн одоогийн тооцоо.

Хөрөнгийн бүртгэл

Өргөдөл гаргагч нь УУҮАТ-ний талбай дахь эдэлбэр газруудыг жагсааж, хэмжээг нь зааж өгөх ёстой. Ашиглалтын эдэлбэр газар нь: ил уурхай, далд уурхайн талбай, боловсруулах үйлдвэр орших дэд бүтцийн талбай, хаягдал хадгалах газар, үерийн/ хаягдал чулуулаг байршуулах талбай, нөөцийн материаллаг талбай, ус зохицуулалтын талбай. Хоёрдогч эдэлбэр газар нь олборлолтын дараахь газар ашиглалтыг илтгэх ба үүнд: дэд бүтэц, ус зохицуулалтын талбай, нөхөн сэргээлтийн талбай (бэлчээр, хөвч, ой мод, хөдөө газар гэж тэмдэглэгдсэн), хээр газар, сул талбай зэрэг багтана. Эзэмшил талбай тус бүрийн томоохон хөрөнгийг тооцож гаргасан байх ёстой ба, үүнд шаардлагатай бол ашиглалтын хэмжээ, мөрийн талбай, өндрийг заасан тэмдэглэгээ бүхий суурин үйлдвэр, дэд бүтэц (бутлуурын станц, боловсруулах үйлдвэр, төмөр замын гогцоо, албан байгууллага гэх мэт) -ийг оруулах ёстой.

Хайгуул

Өргөдөл гаргагч нь төлөвлөсөн хайгуулын үйл ажиллагаа, ашиглалтын тусгай зөвшөөрлийн шаардлагыг тодорхойлж, тайлбарлах ёстой бөгөөд хэрэв шаардлагатай бол уурхайн эргэн тойрондох хайгуулын тусгай зөвшөөрөл, ашиглалтын лиценз (үүд) дээр хайгуулын үйл ажиллагаа явуулж болно. Хайгуулын үйл ажиллагаанд дараахь зүйлийг хамруулж болох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

- Өрөмдлөгийн төрөл (агаарын тэсэлгээ, агаар шахах, урвуу өрөмдөлт, хувилагч шавар, алмаазан гол);
- Ашиглагдах магадлалтай геофизикийн арга (жишээлбэл, цооногийн хайгуул, соронзон орон, таталцлын хүч, индукцэлсэн туйл, газар хөдлөлт);
- Хайгуулын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай газар шорооны ажил (жишээлбэл өрөмдлөгийн талбай, ус шавхуурга, нэвтрэх ховил); болон
- Хайгуулын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж.

Барилга

Өргөдөл гаргагч нь УУҮАТ-ний хугацаанд төлөвлөсөн барилга байгууламж, нураах үйл ажиллагааг тодорхойлж, тайлбарлах ёстой. УУҮАТ-ний хугацаанд санал болгож буй аливаа өөрчлөлтийн хамт одоогийн үндсэн дэд бүтцийг тодорхойлох шаардлагатай.

Уул уурхайн үйл ажиллагаа

Уурхайн бүтээн байгуулалт, дараалал тогтоох аргыг уурхайн ерөнхий үзүүлэлтийн хамт тайлбарлах ёстой. Өмнө нь сэргээн засварласан газруудыг хөндөх төлөвлөгөөний талаар мөн заавал тусгах ёстой. Уул уурхайн үйл ажиллагааны тодорхойлолтод дараахь зүйлийг ихэвчлэн багтаадаг:

- Батлагдсан олборлолтын арга (газар доорхи, ил уурхай гэх мэт), хүдэр боловсруулах (бутлах, угаах, нунтаглах, хөвүүлэн баяжуулах, уусгах гэх мэт);
- Машины төрөл, хэмжээ, хүчин чадал, дуу чимээ, утаа гаралт, асаагуурын эх үүсвэр (утааны яндан), ба ойролцоо нэгжийг нь тодорхойлсон тоног төхөөрөмж;
- Одоо явагдаж буй аливаа ажилтай холбоотой эхлэх үйл ажиллагааны дараалал, эхлэх цэг, дэвшилтэт ажлын үе шатуудын чиглэл;
- Ажиллагааны горим (тасралтгүй эсвэл тодорхой цаг хугацааны давтамжтай) ба санал болгож буй ажлын цаг, өдөр;
- Тэсрэх материалын төрөл, тэсэлгээний тооцоолсон давтамж, тэсрэх материалыг хадгалах (хэмжээ, нарийвчилсан байршил, хадгалах арга), үүнд тэсэрч дэлбэрэх бодис ашиглахыг зөвшөөрсөн аливаа лицензийн хуулбарыг багтаасан; болон
- Хүдэр, бүтээгдэхүүн, газрын хэвлий, хөрсний овоолгын байршил, хэмжээ, хэлбэр, өндөр, түүнчлэн байрлуулах арга, тогтворжуулах ба элэгдлийг хянах арга, овоолгоор дамжих усны урсац.

Чулуулаг / хөрс чулуулаг байрлуулах

Өргөдөл гаргагч нь нүүлгэн байрлуулах, нүүлгэн байрлуулах дараалал, нүүлгэн байрлуулах барилга байгууламж, нүүлгэн байрлуулах зохицуулалтыг тодорхойлсон байх ёстой. Ихэвчлэн чулуулаг нүүлгэн байрлуулах дараахь зүйлийг багтаана:

- Уурхайн байнгын ба түр зуурын хаягдал чулуулгийн агуулахын байршил, хэмжээ, хэлбэр, өндөр;
- Байрлуулах арга;
- Хадгалах байгууламжийг тогтворжуулах, элэгдлийг хянах арга;
- Хүлээн зөвшөөрсөн аюулгүй байдлыг харуулах налуугийн тогтвортой байдлын үнэлгээ; болон
- Эвдэрсэн, сэргээн засварласан газруудад гадаргын усны урсацын хяналт.

Бутлах, боловсруулах

Боловсруулах үйлдвэрүүдийн техникийн нөхцлийн талаар дараахь мэдээллийг өгөх шаардлагатай:

- Ашигт малтмал эсвэл нүүрсийг газар дээр нь боловсруулахад ашигладаг суурин буюу зөөврийн үйлдвэр ба холбогдох байгууламж (бетон зуурмагийн үйлдвэр,

дугуй угаах байгууламж, дарш, түлшний сав, усны сав, химийн агуулах гэх мэт)-ийн талбай, хэмжээ, барилгын төрөл, байршил;

- Чулуулаг эсвэл элсний боловсруулалтын тайлбар (жишээлбэл бутлах, угаах, хатаах, шигших, ялгах)
- Түүхий эдэд ашигласан боловсруулалт / нэмүү өртгийн төрөл (үүд) (жишээлбэл бетон, битум, ялгах, хатаах);
- Боловсруулах ус ашиглаж байгаа бол усны баланс, шаардагдах усны хэмжээ, эх үүсвэр;
- Угсралтын бүх хатаах болон бусад халаалтын ажилд зориулагдсан уурхайн усны дулааны ачаалал;
- Үйлдвэрийн массын тэнцвэр
- Дуу чимээний эх үүсвэр;
- Тоосны эх үүсвэр ба найрлага; болон
- Асаагуурын эх үүсвэр; болон
- Бутлах, боловсруулах, бүтээгдэхүүн тээвэрлэх санал болгосон цаг, өдөр.

Хаягдал ба боловсруулалтын үлдэгдэл

Хаягдлын байгууламж, устгах арга, байршлыг тогтоож товч тайлбарласан байх ёстой. Ерөнхийдөө аливаа боловсруулалтын хог хаягдлын талаар дараахь мэдээллийг өгнө:

- Хаягдал боловсруулах усны хэмжээ, үлдэгдэл дэх усны агууламж, устгал, дахин боловсруулах арга;
- Химийн нэмэлт бодисын зохицуулалт ба устгал (жишээлбэл, хөвсгөр бодис); болон
- Шламын зохицуулалт ба устгал.

Хаягдал материалын зохицуулалт

Өргөдөл гаргагч нь УУҮАТ-ний хугацаанд хог хаягдлыг зайлуулах, материал боловсруулах үйл ажиллагааг тайлбарлах ёстой. Үүнд угааж болдог хог хаягдал, нүүрс устөрөгч, аюултай материалыг зайлуулах, бохирдсон хөрсний зохицуулалтыг багтаасан байх ёстой. Ерөнхийдөө аливаа үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлын талаарх мэдээлэлд дараахь зүйлсийг тусгана:

- Хог хаягдлыг зайлуулах байгууламж, тоо, хэмжээ, байршил, барилгын дэлгэрэнгүй мэдээлэл;
- Тос;
- Бусад газар дээрх хог хаягдлыг зайлуулах буюу дахин боловсруулах (жишээлбэл, цехийн хог хаягдал, дугуй, бортого, тосны шүүлтүүр);
- Уурхайгаас гадуур зайлуулах;
- Тухайн газарт суурилуулсан бохир усны системийн төрөл, талбай, зохион байгуулалтын тодорхойлолт, болон уг системийг холбогдох байгууллага баталсан буюу зөвшөөрсөн бол.

Дэд бүтэц

Дэмжлэг үзүүлэх дэд бүтцийн талаар дараахь мэдээллийг өгөх шаардлагатай:

- Газар дээр нь ашиглах боловсон хүчний байр, вагон караван, бааз болон түүнтэй холбоотой барилга байгууламж (жишээлбэл, автомашины зогсоол, албан газрын барилга, цайны газар, усан цөөрөм)-ийн тоо, талбай, хэмжээ, барилга байгууламжийн төрөл, байршил; мөн түр эсвэл байнгын эсэх;
- Цахилгаан, ус, утас зэрэг уурхай, карьерт нийлүүлдэг гадны үйлчилгээний эх үүсвэрүүдийн тодорхойлолт;
- Нийтийн дэд бүтцэд шинээр холбогдох шаардлагатай тохиолдолд санал болгож буй холболтын чиглэл;
- Уул уурхайн үйл ажиллагаанд нөлөөлсөн эсвэл нөлөөлж болзошгүй хуурай замын дэд бүтцийн тодорхойлолт, үр дагавар;
- Өдөрт хүлээгдэж буй тээврийн хэрэгслийн нарийвчилсан мэдээллийг багтаасан шинэчлэгдсэн буюу шинэчлэхийг санал болгосон нийтийн эзэмшлийн зам талбай, уурхай, карьерт буцаж ирэх тээврийн систем(үүд) ба хэрэгслийн тоо;
- Одоо байгаа эсвэл санал болгож буй аливаа ургамлын тодорхойлолт (өөрөөр хэлбэл тарих зүйл, нягтрал) эсвэл бусад төрлийн дүрс бичлэгийн скрининг; болон
- Хашаа барих, тэмдэг зоох зэрэг хүмүүс зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн дэд бүтэц, арга хэмжээний ерөнхий тодорхойлолт.

Ашиглалтаас гаргах, буулгах үйл ажиллагаа

Өргөдөл гаргагч нь УУЯТ-ний үйлчлэх хугацаанд ашиглалтаас хасагдах болон / эсвэл нураах талбай, байгууламжийг тодорхойлж, тайлбарлах ёстой.

Түр зуурын тогтворжилт

Өргөдөл гаргагч нь түр зуурын тогтворжуулах ажлын байршил, түүнийг хэрэгжүүлэх болсон шалтгааныг тодорхойлох ёстой. Санал болгож буй газрын хэв маяг, тогтворжуулах арга, түр нөхөн сэргээлтийн хугацааны талаархи мэдээллийг тодорхойлж өгөх хэрэгтэй.

Лаг, ус зайлуулах сувгийн хяналтын мэдээлэлд дараахь зүйлийг багтаасан байх ёстой:

- Лагийн менежментийн байгууламжийн байршил, зураг төсөл (жишээлбэл лагийг хадгалах далан);
- Эвдэрсэн, сэргээн засварласан газруудын урсацын хяналт; болон
- Цэвэр усыг хадгалах, өөрчлөх, зайлуулах (өөрөөр хэлбэл холбогдох хууль тогтоомжийн дагуу ус зайлуулах).

Дэвшилтэт нөхөн сэргээлт

Өргөдөл гаргагч нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд УУЯТ-ний хугацаанд нөхөн сэргээгдэх талбай, нөхөн сэргээлт хийгдэж байгаа эсвэл дуусах бүх газрыг тодорхойлж, тайлбарлах шаардлагатай.

Үйлдвэрлэлийн хуваарь

Доорхи хүснэгтэд харуулсан хэлбэрээр нэгтгэн материалын үйлдвэрлэлийн хуваарийг гаргах шаардлагатай.

Хүснэгт 1: УУАТ-ний хугацаанд материал үйлдвэрлэх хуваарь

Материал	Нэгж	1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил
Цөлмөсөн шороон хөрс	м ³					
Хаягдал чулуулаг/Хөрс чулуулаг	м ³					
Хүдэр эсвэл ROM нүүрс	Мт					
Акталсан материал	Мт					
Бүтээгдэхүүн	Мт					
Хучилтын материал	Мт					

Акталсан материалд (шаардлагатай тохиолдолд) хаягдал, том ширхэгтэй акталсан болон баяжуулалтаас үүдэлтэй бусад хог хаягдал орно. Хучилтын материалыг хаягдал чулуулаг, акталсан материал, эсвэл ил уурхайн зориулалтын карьерын үйл ажиллагаанаас үүссэн гэж тодорхойлсон байх ёстой.

Байгаль орчны эрсдлийн үнэлгээ

[Энэ тайлангийн хүрээнд хамаарахгүй]

Байгаль орчны эрсдлийн менежмент

[Энэ тайлангийн хүрээнд хамаарахгүй]

Олборлолтын дараахь газар ашиглалт

[Энэ тайлангийн хүрээнд хамаарахгүй]

Нөхөн сэргээлтийн төлөвлөлт, менежмент

[Энэ тайлангийн хүрээнд хамаарахгүй]

Тайлан гаргах

Өргөдөл гаргагч нь УУАТ-тэй нийцэж байгаа эсэхийг шалгахад шаардагдах төрөл бүрийн тайланг гаргах аргачлалыг жагсаах шаардлагатай.

Төлөвлөгөө

Төлөвлөгөө нь судалгаа, ортофото зураг эсвэл агаарын зурганд үндэслэгдсэн байх ёстой ч судалгааны төлөвлөгөө болгон хүлээн авч болно.

Бүх төлөвлөгөөнд дараахь зүйлийг тусгасан байх ёстой.

- уурхайн нэр;
- эзэмшигчийн нэр;
- төлөвлөгөө боловсруулсан огноо;
- төлөвлөгөөний нэр;
- төлөвлөгөөг хэн бэлтгэсэн;
- зөвшөөрлийн зааг;
- төсөл батлах газар (өөрөөр хэлбэл бүтээн байгуулалтын зөвшөөрөлд тодорхойлсон ашиглалтын талбай);
- төслийн хөндөх бүс;

- зохих хариуцлагатай албан тушаалтан, өөрөөр хэлбэл менежер эсвэл эрх эзэмшигчийн гарын үсэг;
- хил хязгаар, тусгай зөвшөөрлийн дугаар зэрэг уул уурхайн зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- хойд цэг;
- суурь антенны эх үүсвэрийн огноо;
- масштаб - масштаб нь холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг тодорхой харуулах боломжийг олгох ёстой;
- сүлжээ шугам (MGA);
- гадаргын контур (нүүрсний уурхайн хувьд 5 метрийн зайтай байх стандарттай байдаг боловч зарим газарт 1 метр ба түүнээс бага зай шаардагдах магадлалтай (үйлдвэрлэлийн талбай, төмөр замын гогцоо гэх мэт)); ба
- тэмдэг ба өнгөний ялгах тэмдэг.

Төлөвлөгөөнд тусгах нийтлэг зүйл:

- төсөл хэрэгжих газар (улсын хэмжээний төслийн хувьд хамгийн ойр байрлах орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон томоохон хот, тосгоныг тодорхойлох);
- байгаль орчны нөхцөл (олборлолтын өмнөх нөхцөл байдлыг тодорхойлох)
- Бүтээн байгуулалтын нөхцөл (олборлолтын өмнөх);
- УУУАТ-ийг хэрэгжүүлж эхлэх үеийн уурхайн эдэлбэр газар (үйл ажиллагаа явуулдаг эдэлбэр болон уурхайн дараах газар ашиглалтын хоёрдогч эдэлбэр);
- УУУАТ хэрэгжих хугацаанд хийх олборлолт болон нөхөн сэргээлтийн ажлын үргэлжилсэн төлөвлөгөө (жилээр харуулсан);
- эцсийн нөхөн сэргээлт ба ашиглалтын дараах газар ашиглалтын төлөвлөгөө; болон
- эцсийн нөхөн сэргээлт ба олборлолтын дараах газрын урт ба хөндлөн огтлолуудын ашиглалт

Хөндлөн огтлолууд

Малтлага, нүүлгэн шилжүүлэлтийн санал болгож буй геометрийг тодорхой зааж өгсөн хэмжээгээр хөндлөн огтлол ба уртын хэсгүүдийг зохих сонголтыг хийх шаардлагатай.

Бусад улс орнуудын жишээ

Дор дурдсан улс орнуудын хоорондын ялгаа дараах байна: уул уурхайн салбарын хэмжээ, нийтийн албаны цар хүрээ, боломжит нөөц, уул уурхайн эдийн засаг дахь ач холбогдол, олон нийтийн ойлголт.

Нью Соут Вэйлс (Австрали Улс)

Нью Соут Вэйлс муж (НСВ) нь Сиднейн сав газрын хойд, өмнөд, баруун захад нүүрс олборлодог томоохон талбайнуудтай. Тус мужийн баруун ба баруун дунд хэсэгт дэлхийн хэмжээний олон тооны газар доорх суурь металлын уурхай, дунд болон том хэмжээний алтны уурхай байдаг ба тухайлбал жилд 900,000 унц алт олборлодог Австралийн хамгийн том алтны уурхай болох Кадиа байрладаг байна.

Нью Соут Вэйлс-ийн уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө нь Загвар 4-д заасан журмын дагуу явагддаг. Энэхүү төлөвлөгөө нь магадгүй тус тайланд дурдсан жишээ загваруудын хамгийн нарийн төвөгтэй нь бөгөөд байгаль орчны хариу арга хэмжээ, нөхөн сэргээлтийг хангах, хянахад чиглэсэн болно. Энэ нь хэд хэдэн байгууллагын чиг үүрэгт хамаардаг бичиг баримт бөгөөд хяналтыг уул уурхайн зохицуулагч байгууллагад

илүү төвлөрүүлсэн. Ашиглалтын талбайн дийлэнх хэсэг нь үржил шимтэй, өрсөлдөөн ихтэй газар нутагт байрладаг тул Нью Соут нь олон нийтийн оролцоо болон хяналтыг тухайн улсын бусад мужийн уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдээс илүү өндөр төвшинд хэрэгжүүлдэг. Ялангуяа нүүрсний олборлолтын гол бүс болох Хантер Валлэй /Hunter Valley/ нь усан үзмийн цэцэрлэг, адууны ферм, эрчимжсэн хөдөө аж ахуй, бэлчээрийн газар төвлөрсөн бүс юм.

Нью Соут Вэйлс мужийн уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулга нь өмнө нь дурдсан 'Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах мэдээлэл' хэсэгт тодорхойлсон агуулгатай адил. Эрх бүхий байгууллагаас уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад зориулсан гарын авлага эрхлэн гаргадаг бөгөөд одоогийн гарын авлага нь 79 хуудастай байна. Ашигт малтмал олборлолтын хэсгийн агуулгын шаардлага нь бусад мужуудтай харьцуулахад тодорхой бус байдаг боловч хүрээлэн буй орчинд хамаарах төлөвлөгөөний хэсгийн агуулга нь илүү нарийвчилсан бөгөөд үр дүнд чиглэсэн байдаг. Тухайлбал, жагсаалтад тусгагдсан мэдээлэл (нүүр хуудас болон төлөвлөгөөнөөс бусад) нь хэвлэн нийтлэгдсэн гарын авлагын агуулгад тусгагдахгүй хэдий ч уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд бүрэн тусгагдах ёстой бөгөөд эрх бүхий байгууллагаас олгосон байгаль орчны тусгай зөвшөөрөлд тусгагдсан байж болох юм.

Нью Соут Вэйлс мужийн уул уурхайн зохицуулагч байгууллага тус байгууллагад ирүүлсэн Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор хянан хэлэлцэнэ. Гэвч эрх бүхий албан тушаалтнаас Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөний баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, тодруулга авах шаардлагатай тохиолдолд дээрх төлөвлөгөөг хянан хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх зохицуулалтыг хэрэглэх буюу хугацааг зогсоох боломжтой. Хугацааг түдгэлзүүлэх гэдгийг түдгэлзүүлсэн өдрөөс хойш хугацааг дахин сэргээх хүртэлх хугацаа нь хүсэлт хянан шийдвэрлэх хугацааг тогтооход тоологдохгүй гэж ойлгоно. Иймд эрх бүхий байгууллагаас өмнөх Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа дуусахаас 3 сарын өмнө Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг ирүүлэхийг зөвлөдөг. Зохиогчийн туршлагаас үзэхэд, Нью Соут Вэйлс-д хэрэгжилт төслийн талаар хүсэлт гаргагч нь өөрийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахын тулд шинэчилсэн Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэхээр товлосон өдрөөс 6 сарын өмнө эрх бүхий байгууллагад Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүсэлтээ гаргах нь зүйтэй.

Нью Соут Вэйлс мужийн уул уурхайн зохицуулагч байгууллага нь Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байх баримт бичиг гэж үздэг. Эрх бүхий байгууллагын тухайн үйл ажиллагаа хэрэгжүүлэх газрыг харьяалах орон нутгийн газраас энэхүү уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг (хуулбарлалгүй) шууд үзэж танилцах нөхцөлийг бүрдүүлсэн байдаг. Эрх бүхий байгууллагаас нийтийн ашиг сонирхолд нийцсэн гэж үзвэл Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд түгээх боломжтой. Эрх бүхий байгууллагаас Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг өөрийн цахим хуудсанд нийтлэхдээ холбогдох этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан худалдаа, арилжаа болон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг хасна.

Хойд нутаг дэвсгэр (Австрали Улс)

Хойд нутаг дэвсгэрийн хүн амын нягтаршил сийрэг (0.25 сая орчим) тул жижиг хэмжээ бүхий уул уурхайн салбар нь бүс нутгийн эдийн засагт харьцангуй өндөр нөлөө үзүүлдэг. Алт, уран болон суурь металлын уурхай нь ихэвчлэн жижиг, дунд хэмжээний байдаг боловч энд Карпентариагийн булангийн ойролцоох дэлхийн хэмжээний McArthur голын

цайрын хар тугалганы уурхай болон Гроот Эйландт арал дээрх GEMCO манганы уурхай байдаг.

Хойд нутаг дэвсгэрийн Уул уурхайн менежментийн төлөвлөгөө нь Загвар 4-т хамаарна. Австралийн Хойд нутаг дэвсгэрийн Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулга нь өмнө дурдсан 'Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах мэдээлэл' хэсэгт тодорхойлсон агуулгатай ерөнхийдөө адил. Уул уурхайн зохицуулагч байгууллагаас уул уурхайн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан гарын авлага эрхлэн гаргадаг бөгөөд одоогийн гарын авлага нь 33 хуудастай байна. Нью Соут Вэйлс зэрэг бусад муж улсуудтай харьцуулахад санал болгож буй үйл ажиллагааны шинж чанарт тавигдах шаардлага нь илүү нарийвчилсан байдаг бөгөөд энэ нь хүсэлт гаргагчийн тухайн салбарт явуулж буй үйл ажиллагааны нийцлийг хангахад илүү хялбар болгодог. Өмнөд Австралийн Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харьцуулахад ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаатай холбоотой шаардлагын агуулга нь илүү нарийвчилсан байх боловч зохион байгуулалтын хувьд нэлээд төстэй юм. Уул уурхайн менежментийн төлөвлөгөө боловсруулах гарын авлага нь тусгах шаардлагатай агуулгыг тусгасан эсэхийг шалгах хуудастай байдаг.

Уул уурхайн менежментийн төлөвлөгөөнд ерөнхийдөө дараах агуулгыг шаарддаг. Үүнд:

- Танилцуулга (операторын дэлгэрэнгүй мэдээлэл, байгууллагын бүтэц болон хариуцлага, ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл, төсөл хэрэгжих газрын байршил, төслийн тойм ба сайжруулалт);
- Талбайн нөхцөл байдал (уур амьсгал, газрын тогтолцоо, ургамал, амьтан, газар ашиглалтын одоогийн нөхцөл байдал, сонирхогч талууд болон зөвлөгөөн, ажиллах хүчний тодорхойлолт, хүн ам зүй, олон нийтийн харилцаа)
- Тавигдах шаардлага (хууль ёсны шаардлага, бусад шаардлага болон соёлын өв газар);
- Хэрэгжүүлэх үйл ажиллагаа (ашигт малтмал олборлолт, уурхайн зураг төсөл, хаягдал чулуулгийн овоолго, уул уурхайн нөөц ба геологи, өмнөх Уул уурхайн менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн олборлолтын үйл ажиллагаа, хүдэр боловсруулах үйл ажиллагаа, үлдэгдэл / хаягдал хадгалах байгууламж, боловсруулах / уурхайн усны далан, өмнөх Уул уурхайн менежментийн төлөвлөгөөний дагуу явуулсан боловсруулах үйл ажиллагааны хэрэгжилт, хайгуулын үйл ажиллагаа);
- Байгаль орчны менежмент [*энэ тайлангийн хүрээнд хамаарахгүй*];
- Усны менежментийн төлөвлөгөө (одоогийн нөхцөл байдал, мэдээлэл / мэдлэгийн зөрүү, усны баланс, эрсдэлийн удирдлага, хяналт, менежмент, тайлангийн хугацаанд санал болгосон арга хэмжээ, тэдгээрийн усны чанарт нөлөөлөх боломж);
- Ослын талаар мэдээлэх;
- Хаалтын төлөвлөлт (төлөвлөгдөөгүй хаалт, зардал тооцох суурь үнэлгээ, аюулгүй байдлын тооцоо);
- Хавсралт (эрсдэлийн үнэлгээний матриц, хаягдал чулуулгийн шинж чанар, менежмент, аюултай бараатай харьцах, хадгалах, нэмэлт мэдээлэл, диаграмм, товчлол).

Уул уурхайн менежментийн төлөвлөгөө нь нууцад хамаарах баримт бичиг бөгөөд олон нийт нээлттэй танилцах боломжгүй байна.

Күинслэнд (Австрали Улс)

Күинслэнд нь Австрали улсын уул уурхайн салбар хөгжсөн хамгийн том хоёр муж улсын нэг нь юм. Күинслэнд нь Австралийн нүүрс олборлодог хамгийн том муж бөгөөд

төмөрлөгийн болон эрчим хүчний нүүрсийг олон газраас олборлодог бөгөөд ялангуяа Боуэн сав газарт олборлолт төвлөрч байна. Дэлхийн хэмжээний Mount Isa зэс/хар тугалга/ цайрын уурхай нь тус мужийн баруун хойд хэсэгт буюу цөөн тооны суурь металлын үйл ажиллагаа явуулдаг бүс нутагт байрладаг. Бусад дунд хэмжээний алт, суурь металлын уурхай нь мужийн зүүн, зүүн хойд хэсэгт байрладаг.

Байгаль орчны мэдээллээс тусдаа байдлаар уул уурхайн мэдээллийн талаар Күинслэнд муж нь Загвар 2-ыг нэвтрүүлсэн. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл авах, тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлт гаргахдаа өргөдлийн хамт Уул уурхайн хөтөлбөрийг ирүүлэх ёстой. Өмнө нь дурдсанчлан, уул уурхайн хөтөлбөрийн цар хүрээ нь үйл ажиллагааны хэмжээ, нарийн төвөгтэй байдлаас хамааран харилцан адилгүй байдаг.

Күинслэндийн Байгаль орчин ба Шинжлэх ухааны хэлтэст өргөдөл гаргагч нь өөрийн “үйл ажиллагааны төлөвлөгөө” (Загвар 4-тэй адил)-г ирүүлнэ. Энэ нь төслийн Байгаль орчны зөвшөөрлийн нийцлийн асуудалтай ихээхэн холбоотой тул энэ тайланд нарийвчлан авч үзээгүй болно. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь дээд тал нь 5 жилийн хугацаатай байна.

Өмнөд Австрали


Өмнөд Австралид дэлхийн түвшний Олимпын далангийн зэс-алт-ураны уурхай байрладаг бөгөөд үүнээс гадна цөөн тооны суурь металл болон төмрийн хүдрийн уурхай үйл ажиллагаа явуулж байна.

Өмнөд Австралийн Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө нь Загвар 4-ыг нэвтрүүлсэн байна. Хэдийгээр зохицуулагч байгууллага харилцан хамааралтай бүлэг үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл тус бүрд Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө ирүүлэхийг хүлээн зөвшөөрдөг боловч бүлгийн үйл ажиллагааг хамруулсан нэг Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх нь илүү үр дүнтэй гэж үздэг байна.

Өмнөд Австралийн Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулга нь өмнө дурдсан 'Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах мэдээлэл' хэсэгт тодорхойлсон агуулгатай ерөнхийдөө адил. Уул уурхайн зохицуулагч байгууллагаас уул уурхайн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан гарын авлага эрхлэн гаргадаг бөгөөд одоогийн гарын авлага нь 66 хуудастай байна. Хойд нутаг дэвсгэрийнхтэй адил, Нью Соут Вэйлс зэрэг бусад муж улсуудтай харьцуулахад санал болгож буй үйл ажиллагааны шинж чанарт тавигдах шаардлага нь илүү нарийвчилсан байдаг бөгөөд энэ нь хүсэлт гаргагчийн тухайн салбарт явуулж буй үйл ажиллагааны нийцлийг хангахад илүү хялбар болгодог..

Гэвч Нью Соут зэрэг бусад муж улсуудтай харьцуулахад төлөвлөгөөг батлах үйл явц нь илүү тодорхой байх бөгөөд давж заалдах албан ёсны журмыг оруулсан байна (Схем 1-ээс үзнэ үү). Эхний алхам бол өргөдөл гаргагч нь Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах үйл ажиллагааны зорилго, шалгуурын төслийг ирүүлэх ёстой. Эрх бүхий байгууллагын удирдлага нь багц зорилго, шалгуурын төслийг хүлээн зөвшөөрөх, эсхүл (өргөдөл гаргагчтай зөвлөлдсөний үндсэн дээр) нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж болно. Давж заалдах гомдлыг Вардены Шүүх / Warden's Court/-д гаргах боломжтой. Тус шүүх нь (i) Эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийг баталгаажуулах буюу хэвээр үлдээх; (ii) Эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрт өөрчлөлт оруулах, эсхүл шийдвэрийг хүчингүй болгох; (iii) шаардлагатай гэж үзсэн аливаа бусад үр дагавар бүхий тушаал, захирамж зэрэг шийдвэрийн аль нэгийг гаргана.

Уурхайчдад зориулсан удирдамж: Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө бэлтгэх



Зураглал 1 “Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт болон шалгуурыг батлах үйл явц”

Уул уурхайн үйл ажиллагааг зохицуулах удирдамж, Хувилбар 1, 2012 оны 5 сарын 4
Уул уурхайн тухай хууль, 1997; Уул уурхайн журам, 2011

Өмнөд Австрали нь 2020 оны 02 дугаар сард УУҮАТ (уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө)-ийн хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор жилийн тайлангийн шинэ журмыг баталсан. Ийнхүү жилийн тайланд дараахыг тусгах шаардлагатай. Үүнд:

- Нийтийн хариуцлагын даатгалд даатгуулсан тухай гэрчилгээний хуулбар хувь
- Тодорхойлолт мэдээлэл (ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаарууд, уурхайн үйл ажиллагааны нэр, байршлын талаарх ерөнхий мэдээлэл, газрын өмчлөгч болон уурхайн үйл ажиллагааг хариуцсан этгээдийн нэр, уурхайн талбай дахь холбоо барих мэдээлэл, тайлант хугацааны огноо болон тайлан хүргүүлэх хугацаа)
- Батлагдсан УУҮАТ-д хамаарах бүх зөвшөөрлийн талбайнуудын товч жагсаалт болон зөвшөөрлийн хугацааны талаарх мэдээлэл, бүх зөвшөөрлийн талбайн хил хязгаарыг харуулсан уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө хамаарна;
- Батлагдсан УУҮАТ-д хамаарах бүх байгаль орчинд нөлөөлөх үр дүн болон зөвшөөрлийг олгох шаардлагыг хангасан тухай буюу олборлолтын үйл ажиллагааны зөвшөөрлийг авахын тулд олж авсан бусад зөвшөөрлүүдийн товч жагсаалт болон зөвшөөрлийн хугацааны талаарх мэдээлэл;
- Батлагдсан УУҮАТ-д тусгагдсан Эрдсийн баялаг болон хүрдийн нөөц (ЖОРК код болон түүнтэй адилтгах КРИРСКО хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын код) тус бүрийн ашиглах боломжтой ашигт малтмалын ордуудын талаарх мэдээлэл, батлагдсан УУҮАТ-д орсон нэмэлт өөрчлөлтийн мэдээлэл мөн хамаарна.
- Ирээдүйн олборлолтын түвшин болон уурхайн ашиглалтын хугацаанд ноцтой нөлөөлөх боломжтой нөөц болон хүдэр (Тухайлбал, ойр байрлах бусад уурхайн) тэдгээрийн аливаа шинэ шугам зураг болон хайгуулын үйл ажиллагааны талаарх хураангуй;
- Уурхайн нийт ашиглалтын хугацааны тооцооны талаарх мэдээлэл;
- Тайлант хугацаанд олборлосон болон боловсруулсан ашигт малтмалын хэмжээ болон ирэх тайлант хугацаанд олборлож, боловсруулах ашигт малтмалын тооцооллын хураангуй;
- Одоогийн байдлаар зөвшөөрлийн талбайд хураасан хүдрийн тоо хэмжээ, тайлант хугацаанд зөвшөөрлийн талбайнаас гаргасан баяжуулсан бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний хэмжээ, ирэх тайлант хугацаанд гаргах боломжтой хэмжээний тооцооллын хураангуй;
- Тайлант хугацаанд олборлогдсон хэтэрсэн / хаягдал хүдрийн хэмжээ, ирэх тайлант хугацаанд гарах хэтэрсэн / хаягдал хүдрийн хэмжээ, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлснээс хойш гарсан нийт хэтэрсэн / хаягдал хүдрийн хэмжээний хураангуй;
- Үйл ажиллагааг нь тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон батлагдсан УУҮАТ-д тусгагдсан байгаль орчинд гарах үр дагавар (уурхайн ажил дуусгавар болсны үр дагавар хамаарна)-г баримталсан эсхүл баримтлаагүй тухай мэдээлэл;
- Зохио эрх бүхий албан тушаалтан, менежер эсхүл зөвшөөрөл эзэмшигчийн гарын үсэг;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл, хил хязгаар болон тусгай зөвшөөрлийн дугаар зэрэг; болон
- Энэхүү тайланд хамаарахгүй, байгаль орчинд холбогдох зохицуулалтыг баримтлах тухай цуврал мэдээлэл.

Батлагдсан УУҮАТ-ний зорилго шалгуурын багц нь нээлттэй бөгөөд олон нийт, иргэд хүсэлт гаргаснаар уншиж танилцах боломжтой байна.

Тасмани (Австрали Улс)

Тасмани арал нь Австрали тивийн өмнөд зүгт байрлах муж бөгөөд хэмжээ болон хүн амын хувьд хамгийн жижиг (нутаг дэвсгэрийг хамруулахгүй) нь юм. Тус газарт нэг том төмрийн хүдэр (соронзон гүр)-ийн уурхай, дунд хэмжээний хэд хэдэн алт, цагаан тугалга болон суурь металлын уурхай байдаг.

Тасмани нь тодорхой тайлан, мэдээллийн эх сурвалжийг уурхайн талбайд боловсруулж, хадгалахыг шаарддаг. Жагсаалт нь нийтэд хэрэгждэг бөгөөд хөрөнгө оруулалтын зардал, үйл ажиллагааны зардал, гадаргуу болон газрын хэвлийн бүх ажиллагаануудын нарийвчилсан төлөвлөгөөнөөс бүрддэг. Эрх бүхий байгууллагын даргын хүсэлтийн дагуу уурхайн үйл ажиллагааг хариуцсан этгээд нь тэмдэглэл, төлөвлөгөө болон бусад мэдээллийн хуулбар хувийг гаргаж өгөх ёстой. Тасманийн зохицуулалт нь Загвар 3-т заасан мэдээллийн жагсаалттай адил байна.

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацаанд тусгай зөвшөөрлийн тайлангууд нууцад хамаарч хадгалагдана.

Виктория (Австрали Улс)

Виктория нь Австралийн түүхэн дэх хамгийн эртний алт олборлолтын томоохон хэмжээний бүс нутаг байсан боловч одоогоор түүний уул уурхайн салбар нь нэлээдгүй уналтад орсон байна. Одоо үйл ажиллагаа эрхэлдэг ганц дунд хэмжээний алтны уурхай (Фостервилл) болон алт, бусад ашигт малтмалын үйл ажиллагаа эрхэлдэг хэд хэдэн жижиг, дунд хэмжээний уурхай байдаг. Виктория мужийн зүүн хойд бүсэд байрлах эрчим хүчний үйлдвэрлэлийг хангаж буй хүрэн нүүрс олборлох томоохон талбайн хэмжээг хүрээлэн буй орчны асуудалтай холбогдуулан багасгаж байна.

Виктория мужид уурхайн барилгын ажил, үйл ажиллагаа эхлэхээс өмнө ажлын төлөвлөгөөг хүргүүлж, батлуулахыг шаарддаг. Зохицуулагч байгууллагын зүгээс ажлын төлөвлөгөө гаргах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор 100 хуудас бүхий зааврыг хэвлэн нийтэлдэг байна.

Зохицуулагч байгууллага өөрийн үзэмжээр бага эрсдэл бүхий уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид ажлын төлөвлөгөө гаргаж өгөхийг шаардахын оронд Үйл ажиллагааны тухай хуулийн зарим буюу бүх заалтуудыг дагаж мөрдөх байдлаар зөвшөөрөл олгож болдог. Бага эрсдэл бүхий уурхайг дараах байдлаар тодорхойлсон:

- 5 га буюу түүнээс бага хэмжээ бүхий газрыг хамардаг,
- Гүний үйл ажиллагаа орохгүй,
- Тэсрэх үйл ажиллагаа орохгүй,
- Байгаль дахь ургамлыг цэвэрлэх ажиллагаа орохгүй, бөгөөд
- Химийн боловсруулалт ашиглахгүй.

Ажлын төлөвлөгөө нь:

- Хийхээр төлөвлөж буй ажлын мөн чанар, хэмжээг тайлбарласан,
- Байгаль орчин, хүн ам, эсхүл ойролцоох газар, эд хөрөнгө болон дэд бүтцэд уурхайн учруулж болох бүх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн,
- Тодорхойлсон эрсдэлийг арилгах буюу бууруулах, хэрэгжилтийг үнэлэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашиглах арга хэмжээг тусгасан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг багтаасан,
- Орон нутгийнхантай харилцах төлөвлөгөө болон
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг багтаасан байна.

Ажлыг өөрчилсний улмаас эрсдэл нэмэгдсэн, эсхүл эрсдэлийг “дунд” түвшнээс нэмэгдүүлсэн, мөн шинэ ажил, ажлыг өөрчилсний улмаас орон нутгийнхантай харилцах төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө өөрчлөгдсөн бол ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан хүргүүлж, зохицуулагч байгууллагаар батлуулна.

Нэмэлт өөрчлөлтийг хүргүүлэх ажиллагаа нь ажлын төлөвлөгөөг анх хүргүүлсэнтэй адил процесстой байна. Энэхүү процессыг Зураглал 2-т харууллаа:

Зураглал 2: Хүргүүлэхээс өмнөх алхмууд



Эхний байдлаар дараах мэдээллийг оруулах шаардлагатай:

Үйл ажиллагааны тодорхойлолт, үүнд дараах мэдээлэл орно (хэрвээ боломжтой бол):

- Үйл ажиллагааны гүний хэмжээ (ил эсхүл далд уурхай);
- Нээлттэй уурхайн хувьд налуу, дэнжийн мөргөцөг;
- Олборлох аргачлал;
- Жилийн үйлдвэрлэлийн тооцоо (тонноор);
- Агуулах далан (усны/хаягдлын);
- Уурхайн гадуурх хаягдлын таамаглал;
- Байгалын ургамалд нөлөөлөх нөлөөлөл
- Усны урсцын тогтоц, усны урсцыг зогсоох эсэх;
- Газрын доорх усыг таслах эсэх; болон
- Тэслэх ажиллагаа.

- 1) Уурхай өмчлөгч нь холбогдох газрын эзэдтэй арилжааны, эсхүл нөхөн төлбөрийн тохиролцоо хийсэн талаарх нотолгоо;
- 2) Төлөвлөлт, төлөвлөлтийн зөвшөөрөл шаардлагатай эсэх. Төлөвлөлтийн зөвшөөрөл нь ажлын төлөвлөлөөгөөнөөс тусдаа бөгөөд орон нутгийн төрийн байгууллагаас авах зөвшөөрлийг багтаана. Мөн төрөөс гаргасан эд хөрөнгийн төлөвлөлтийн тайлан (үнэгүй гаргадаг) болон газрын эрхийн баримт бичиг (төлбөртэйгөөр гаргадаг);
- 3) Хэмжээ, түлхүүр үгийг харуулсан газрын зураг:

- Тусгай зөвшөөрлийн талбайн булан бүрийн координаттай тусгай зөвшөөрлийн хил хязгаар. Хэрвээ ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж буй бол одоогийн болон төлөвлөж буй хэмжээ;
- Үйл ажиллагааны ул мөр үлдээх хэмжээ;
- Уурхайн гаднах хамгийн ойр байрлах сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй зүйлүүд;
- Геотехникийн эрсдэлийн бүсийн хэмжээ; болон
- Газрын онцлог шинж (жишээ нь гол мөрөн зэрэг) ба дэд бүтэц (өндөр хүчдэлийн цахилгааны шугам, зам, хурдны зам зэрэг).

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өгсөн мэдээллийг зохицуулагч байгууллага нь тухайн этгээдийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд зарлаж болохгүй. **Баруун Австрали**

Баруун Австралид Пилбара бүс нутгийн дэлхийн хэмжээний том төмрийн хүдрийн уурхай, Калгурлигийн өмнөд хэсгээс Вилунагийн хойд хэсэг хүртэл үргэлжлэх Зүүн Голдфилд дэх дунд-том хэмжээний баялаг алтны уурхай байдаг бөгөөд улсын хамгийн том уул уурхайн салбарын хэсэг юм.

Баруун Австралийн зохицуулагч байгууллага нь уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийг дүүргийн уул уурхайн байцаагч нарт мэдэгдэж, Төслийн Менежментийн Төлөвлөгөө (ТМТ) өгөхийг шаарддаг:

- Уурхайд уул уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө; эсхүл
- Уул уурхайн үйл ажиллагааг түр зогсоосны дараа түүнийг дахин эхлэхээс өмнө; эсхүл
- Уул уурхайн үйл ажиллагааг орхихын өмнө; эсхүл
- Уул уурхайн үйл ажиллагааг түр зогсоохын өмнө.

Уул уурхай хариуцсан Улсын Инженерээс бичгээр зөвшөөрөл авах хүртэл үйл ажиллагааг эхлүүлж болохгүй.

ТМТ-д дараах зүйлс багтсан байна. Үүнд:

- Өргөдөл гаргагчийн дэлгэрэнгүй мэдээлэл;

- Барилга угсралт, бүтээн байгуулалт зэрэг уул уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн огноо;
- Уурхайн дэлгэрэнгүй мэдээлэл (уурхайн нэр, байршил, ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо, уурхай байрладаг орон нутгийн захиргааны байгууллага, уул уурхайн үйл ажиллагаа, уул уурхайн үйл ажиллагаа эхлэх огноо, уул уурхайн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн хугацаа);
- Уул уурхайн байршлыг тогтоох GPS (глобал байрлалын систем)-ийн солбицол;
- Үндсэн ажил олгогчийн мэдээлэл (компанийн нэр, бүртгэлийн дугаар, утасны дугаар, и-мэйл хаяг, гудамжны нэр, дугаар, хотын зах, муж, шуудангийн код);
- Төслийн тойм мэдээлэл (төслийн хураангуй, хөгжлийн томоохон үе шатуудын тойм, ажиллах хүмүүсийн тоо, байршил, нэвтрэх боломж, өмнөх уул уурхайн үйл ажиллагааны түүх, ээлжийн ажлын мэдээлэл болон туслан гүйцэтгэгчийн менежмент, дагалдах баримт бичиг);
- Уурхайн геологи (тойм мэдээлэл, уул уурхайн аюулгүй байдалд нөлөөлж болох бүтцийн томоохон онцлог шинж чанарууд, олборлох арга, бүтцийн томоохон онцлог шинж чанар болон уурхайн байгууламжийн уялдаа холбоог харуулсан зохих төлөвлөгөө, хэсгүүд, хүдэр болон хаягдал чулуулгийн чадамжийн үнэлгээ);
- Асбест хэлбэрийн эсхүл ширхэглэг бүтэцтэй материал, мөнгөн ус, хар тугалга, хүнцэл, кадмий, ванади, хром, болон уран зэрэг хор хөнөөлтэй бохирдуулагч бодис байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор хийсэн хүдэр болон хаягдал чулуулгийн хэд хэдэн дээжийн шинжилгээний нарийвчилсан мэдээлэл болон хүдрийн боловсруулалт нь хүнд металл бохирдуулагч бодисыг бий болгож байгаа эсэх үнэлгээ;
- Хэрэв гүний уурхайн олборлолт хийж байгаа бол газар доорх байгууламжид нэвтрэх гол гарц, тоног төхөөрөмжийн төрөл, газар доорх зохион байгуулалт, схем зураг, төлөвлөгөө, боловсруулалт болон цэвэрлэгээний арга аргачлал, хоёр дах гарц, агааржуулалт, геотехникийн ач холбогдлууд, тэсэрч дэлбэрэх бодис болон түлш хадгалах газар доорх аливаа төлөвлөгөөт агуулах болон дагалдах баримт бичгүүд;
- Хэрэв ил уурхайн олборлолт хийж байгаа бол ерөнхий тайлбар, газар доорх усны хяналтын хэмжүүр, ил уурхайн төлөвлөгөө, харилцаа холбоо болон уурхайн хяналт, уурхайн олборлолтын дараалал, тоног төхөөрөмжийн төрөл, геотехникийн ач холбогдлууд, тэсэрч дэлбэрэх бодис болон түлш хадгалах гадаргуу дээрх төлөвлөгөөт агуулах, болон дагалдах баримт бичгүүд;
- Боловсруулах, хайлуулах, болон цэвэрлэх үйлдвэрийн дэлгэрэнгүй мэдээлэл (ерөнхий тодорхойлолт болон схем зураг, аюултай бараа болон хортой бодисын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тоосжилтын хяналт, лаборатори, хүдрийн хаягдлыг зайлуулах, цацраг туяаны аюул болон менежмент);
- Газар ухаж нүх гаргах ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл;
- Порт, материал боловсруулах, барилга угсралт болон бүтээн байгуулалт зэрэг бусад ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл;
- Уурхайн зохион байгуулалт болон барилга байгууламжийг түрээсийн газрын зааг, үндэсний солбицлын сүлжээ болон RL өгөгдлийн түвшинтэй уялдуулан зохих хэмжээгээр харуулсан байршлын ерөнхий төлөвлөгөө (ерөнхий зохион байгуулалт);
- Эдэлбэр газрын ерөнхий талбайг харуулсан газрын зураг;
- Топографик зураглалаар ус зайлуулах шуудууны онцлогийг харуулсан төслийн бүсийн агаарын зураг;
- Усны урсгалын бүтцийн тодорхойлолт, уурхай болон холбогдох байгууламжийн үерийн усанд автах магадлалын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон 100 жилд

нэг удаа тохиож болох үйл явдлуудыг харгалзан үзэж үерийн усны эсрэг авах арга хэмжээ;

- Боловсруулах, хайлуулах, болон цэвэрлэх үйлдвэрийн дэлгэрэнгүй мэдээлэл (ерөнхий тодорхойлолт болон схем зураг, аюултай бараа болон хортой бодис, тоосжилтын хяналт, лаборатори, хүдрийн хаягдлыг зайлуулах, дагалдах баримт бичиг);
- Онцгой байдлын бэлэн байдал, харилцаа холбоо болон хяналт, танилцуулга болон сургалт, дагалдах баримт бичиг;
- Аюулгүй байдлын болон эрсдэлийн удирдлага (аюулгүй байдлыг хангах компанийн үүрэг, эрсдэлийг тодорхойлох, удирдах үйл явц, тогтоосон аюул, эрсдэлийн үнэлгээ болон дагалдах баримт бичиг);

Зохицуулагч байгууллага нь бүрдүүлэх материал хүлээлгэн өгөхөд зориулан шалгах хуудас гаргаж өгдөг.

Америкийн Нэгдсэн Улс

Америкийн зөвшөөрөл өгөх процесс нь Австралитай адил нарийн төвөгтэй бөгөөд Холбооны болон мужийн аль аль түвшинд хэд хэдэн төрийн байгууллагаас зөвшөөрөл авдаг байна. Газрын өмчлөл болон эзэмшлийн өөр өөр ангиллаас шалтгаалан ондоо дүрмүүд үйлчилдэг. Холбооны нийтийн газрын хувьд ашиглалтын болон хайгуулын зөвшөөрлийн асуудлыг АНУ-ын Газрын менежментийн товчоо хариуцдаг байна. Уг Товчооноос шаарддаг Үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулгыг 36 CFR 228.4 журамд тайлбарласан байдаг. Судлаачийн бодлоор энэхүү тайлбар нь ойлгомжтой, тодорхой байдлаараа Австралид байдгийг гүйцэхгүй бөгөөд зохицуулагч байгууллагад үзэмжээрээ илүү нарийвчилсан мэдээлэл шаардах эрх хэмжээг ихээр олгосон харагдаж байна. Гэвч энэхүү журам Товчооны хариуцдаг газрын хэд хэдэн хэсэгт л хамаардаг суурь мэдээллийг агуулдаг байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах мэдээлэл тусгахыг шаарддаг:

- Үйл ажиллагаа эрхлэгч (хэрвээ үйл ажиллагаа эрхлэгч биш бол өргөдөл гаргагчийн), тэдний түрээслэгч, эрх шилжүүлэн авагч, эсхүл томилогдсон этгээдийн нэр, албан ёсны шуудангийн хаяг;
- Үйл ажиллагаа явуулах газрын байрлалыг тогтооход шаардагдах мэдээллийг хангалттай харуулсан газрын зураг, үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор ашиглах одоо байгаа болон төлөвлөгдсөн зам, замын гарц, гадаргууг нь эвдэх газрын байршлын баримжаа, хэмжээ;
- Төлөвлөж буй үйл ажиллагааны төрлийг хангалттай тайлбарласан мэдээлэл, хэрхэн явуулах, одоо байгаа болон төлөвлөгдсөн зам, замын гарцын төрөл, стандарт, ашиглаж байгаа болон цаашид ашиглах тээврийн хэрэгсэл, үйл ажиллагаа явуулах хугацаа, байгаль хамгааллын шаардлагыг хангахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Үйл ажиллагааны төлөвлөгөө дээр дурдсан 3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангахдаа үйл ажиллагаа явуулах бүх хугацаа, үйл ажиллагааг хамрах шаардлагатай. Хэрвээ төлөвлөгөө гаргах явцад энэ нь боломжгүй бол аль болох боломжтой байдлаар эхний төлөвлөгөөг гаргаж, эхний төлөвлөгөөнд тусгагдаагүй аливаа ноцтой хэмжээний газрын гадаргыг эвдэх асуудлыг дараа нь нэмэлт төлөвлөгөөгөөр гаргаж өгнө.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явж байх аль ч хугацаанд Товчооны зүгээс гадаргын онцлог шинжийг ноцтойгоор эвдэж мэдэх байдлыг багасгах арга хэмжээг нарийвчлан тусгаж, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж гэж шаардаж болно.

Товчоо нь үйл ажиллагааны төлөвлөгөөг хянахдаа Дотоод газрын холбогдох хэлтсүүдийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах ба геологийн онцлог тогтоц, хайгуул, бүтээн байгуулалтын онцгой систем, техник, тоног төхөөрөмж болон ашигт малтмалын үнэлгээ, нөөц зэргийн талаарх голлох техникийн асуудлыг авч хэлэлцэнэ. Үүнтэй адилаар уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч АНУ Мэдээллийн департаментын холбогдох байгууллагуудыг оролцуулан төстэй хэлэлцүүлгийг зохион байгуулахыг Товчооноос хүсэж болох ба уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчийн хүргүүлсэн мэдээллийг Дүүргийн байгаль хамгаалагчийн орон нутаг дахь газар хэлтсээс олон нийт танилцан хянаж болохоор хадгална. Ингэхдээ уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчийн худалдааны нууц, санхүү арилжааны мэдээллүүд зэрэг онцгойлон дурдсан мэдээллийг олон нийтэд танилцуулахгүй. Олон нийтэд танилцуулах мэдээлэлд дараах мэдээлэл орж болно (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй):

- Мэдэгдэж буй ашигт малтмалын ордын үнэлгээний дүн эсхүл тойм, байршил, хэмжээ, илэрц, агуулга,
- Хайгуулын цооног, өрөмдлөг, уурхайн малтлагын эсхүл тэдгээрийг хийхээр төлөвлөсөн байршил, болон
- Уурхайн үйл ажиллагаа эрхлэгчийн зохих эрхтэй холбоотой бусад арилжааны мэдээлэл.

Зарим бүсийн бусад байгууллагын шаардлагыг дагаж мөрдөхийн тулд болон нэмэлт мэдээлэл шаардаж хугацаа хожимдуулах магадлалыг хязгаарлахын тулд Товчоо нь Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах нарийвчилсан мэдээллийг жагсаалтыг 43 CFR 3809.401 журмаар гаргаж нийтэлдэг бөгөөд үйл ажиллагааны тайлбарт заавал байх тодорхой шаардлагыг тусгаж өгсөн байдаг.

Баримт бичиг боловсруулагчийн мэргэшил

УУАТ-г ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрийн өмнөөс компанийн ажилтан боловсруулдаг. Өргөдөл гаргагч нь УУАТ-г “зохих мэргэшил, туршлагатай” хүн боловсруулсан бөгөөд УУАТ нь “холбогдох бүх асуудлыг хамаарч, худал төөрөгдүүлсэн мэдээлэл агуулаагүй” болохыг баталгаажуулах бөгөөд Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу, өргөдөлд худал ташаа эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл агуулах нь зөрчилд тооцогдоно.

“Зохих мэргэшил, туршлага” гэдэгт зохиогч(ууд)-ын албан ёсны бүртгэл шаардахгүй боловч шаардлага хангахуйц мэргэжил боловсрол эзэмшсэн байхыг ойлгоно. Тэдгээр шаардлага нь тухайн төлөвлөсөн үйл ажиллагааны цар хүрээ, нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан өөр өөр байна. Ихэнх улс орнуудад, АУУМИ (Австралийн уул уурхай, металлургийн институт) зэрэг мэргэжлийн холбооны гишүүн байх шаардлагыг тавьдаггүй. Гэхдээ, зарим улс оронд (Квийнсланд гэх мэт), муж доторх аливаа барилга байгууламж, малтлагын ажлыг хийж гүйцэтгэх, төлөвлөх бүх инженер Мэргэжлийн Инженерээр бүртгэгдсэн байхыг шаарддаг. Уул уурхайн салбарын хүрээнд, Австралийн уул уурхай, металлургийн институт нь Квийнсландын Мэргэжлийн Инженерүүдийн Зөвлөлийн нэрийн өмнөөс өөрийн Тусгай эрхтэй Мэргэжлийн Хөтөлбөрийн дагуу үнэлгээ, бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэдэг.

Ерөнхийдөө, УУАТ-нд гарын үсэг зурсан этгээд нь бүртгэгдсэн уул уурхайн менежер байна. (Зарим газруудад Талбайн Ахлах Захирал гэж нэрлэсэн байдаг.) Гэхдээ геологи, гидрологийн ажлыг мэргэшсэн геологич, боловсруулалтын ажлыг мэргэшсэн металлургич, дэд бүтцийн ажлыг мэргэшсэн иргэний, механик, цахилгаан инженер, хүрээлэн буй орчны нөлөөллийн ажлыг байгаль орчны мэргэшсэн судлаач хийнэ.

УУАТ болон Техник эдийн засгийн үндэслэлийн хамаарал

Бүтээн байгуулалтын өргөдөл болон эхлэлтийн УУҮАТ нь (Техник эдийн засгийн үндэслэл гэхээс илүү) төрийн байгууллагад хүргүүлдэг анхны баримт бичиг тул эдгээр улс оронд УУҮАТ болон Техник Эдийн Засгийн Үндэслэл хооронд мэдэгдэхүйц хамаарал байдаггүй. Зохицуулагч байгууллага нь бодит үйл ажиллагаа болон үр нөлөөг УУҮАТ-д дурдсан төлөвлөгөөтэй харьцуулах замаар үйл ажиллагаанд хяналт тавьдаг.

Хянах үйл явц ба Зөвшөөрөл

УУҮАТ-г уул уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөхөөс өмнө, эсхүл одоогийн УУҮАТ-ний хугацаа дуусахаас өмнө боловсруулж амжих эсэхийг баталгаажуулахын тулд эхлүүлэхээр төлөвлөсөн огнооноос нэлээн өмнөөс гаргаж өгөх ёстой.

УУҮАТ-г зохицуулагч байгууллагын ажилчдаас бүрдсэн (ихэвчлэн 3-4 хүнтэй) жижиг хороо үнэлнэ. Хороонд техникийн мэргэшсэн мэргэжилтнүүд (ялангуяа уул уурхайн инженерүүд) болон бүс нутаг хариуцсан уул уурхайн байцаагч нарыг нэмж оруулж болно. Мөн байгаль орчны асуудлыг УУҮАТ-нд оруулсан тохиолдолд (ихэнх Австралийн мужуудад оруулахыг шаарддаг), байгаль орчин хариуцсан зохицуулагч байгууллагын төлөөлөгч нь хорооны гишүүн болж ордог. Хорооноос УУҮАТ-г үнэлэхийн тулд байгаль орчны мэргэшсэн мэргэжилтэн нэмж шаардлагатай болсон тохиолдолд байгаль орчны төлөөлөгч уг асуудалд хамтран ажиллана. Гаднын (салбарын) ямар ч мэргэжилтэн үнэлгээний ажиллагаанд оролцохгүй.

УУҮАТ-г үнэлэхдээ зохицуулагч байгууллага нь тодорхой мэдээллийг чухалчилж, хэмжигдэж болохуйц мэдээлэл, өгөгдлийг гаргасан бөгөөд төлөвлөсөн үр дүнг тогтоосон хугацааны дотор бодитоор биелүүлж болохуйц байдлыг хардаг. Хүлээн зөвшөөрөхүйц УУҮАТ нь:

- Эрхлэн гаргасан гарын авлагын агуулга болон хэлбэрийн шаардлагад нийцсэн байх (“Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд дурдсан мэдээлэл”-хэсэгт тайлбарласантай адил);
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл, байгаль орчны зөвшөөрөл болон бүтээн байгуулалтын зөвшөөрөлтэй холбогдох шаардлагуудад нийцсэн байх;
- Аюулгүй ажиллагааны менежментийн төлөвлөгөөтэй нийцсэн байх;
- Сонирхогч бүлгийн оролцоотойгоор боловсруулсан зорилго, үр дүнд суурилсан байх;
- УУҮАТ-нд заасан зорилго, үр дүнд хүрнэ гэдгийг тодорхой харуулах зорилгоор шинжлэх ухааны болон инженерийн үнэлгээ, мөн/эсхүл шаардлагатай тохиолдолд, урьдчилсан хянан магадалгаа зэрэг мэдээллийг хангалттай дэлгэрэнгүй өгсөн байх.

Өөр чиг үүрэг бүхий хэд хэдэн байгууллагад холбогдуулан нэг баримт бичиг гаргаж өгөх тохиолдолд байдаг. Бүх улс орнуудад уул уурхайн зохицуулагч байгууллага нь УУҮАТ-ний өргөдлийг хүлээн авдаг бөгөөд ихэнх улс оронд байгаль орчны зохицуулагч байгууллага нь мөн өргөдлийг авдаг бол зарим улс оронд төлөвлөгөө хариуцсан эрх бүхий байгууллага тэдгээрийг хүлээн авдаг байна. Онтарио (Канад)-д, анхны баримт бичгийг батлахын тулд 8 хүртэлх эрх бүхий байгууллага оролцох тохиолдол байдаг. Зарим Канадын мужуудад, уул уурхайн зохицуулагч байгууллага нь өргөдөл гаргагчтай холбоо барих, мөн бусад оролцогч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор “нэг-үйлчилгээний-цонх”-ыг байгуулахаар оролдож байсан. Зохиогчийн үзэж байгаагаар, энэ нь анх бодож байсан шиг үйл явцыг хялбарчилж чадаагүй. Гэхдээ бараг бүх газар, зөвхөн уул уурхайн зохицуулагч байгууллага нь уул уурхайн шалгуур үзүүлэлтийг (уурхайн налуу, түр зуурын овоолгын налуу гэх мэт) үнэлэхэд оролцож байна.

УУҮАТ-ийг хянах процессын хувьд зохицуулагч байгууллагад өөр өөр чиг үүрэг бүхий өөр өөр ажилтнууд багтдаг. [УУҮАТ] нь:

- Хэлбэр, агуулгын хувьд нийтэлсэн заавар гарын авлагад нийцсэн байх (“УУҮАТ-д тусгах мэдээлэл” хэсэгт дурдсантай адил);
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл, байгаль орчны зөвшөөрөл болон бүтээн байгуулалтын зөвшөөрлийн шаардлагад нийцсэн байх;
- Аюулгүй ажиллагааны төлөвлөгөөнд нийцсэн байх.

УУҮАТ-ний Тайлан ба Хяналт

Зөвшөөрөл олгосон нөхцөлийн дагуу жилийн тайлангуудыг хүргүүлдэг.

Зохицуулагч байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн явуулж буй үйл ажиллагаа нь УУҮАТ-д заасан үйл ажиллагаатай нийцэж байгаа эсэхийг шалгах зорилгоор хэзээ ч аудит хийж болно. Батлагдсан УУҮАТ-ийг дагаж мөрдөөгүй бол зөрчилд тооцогдоно.

Нууцлал

Баримт бичиг нь ихэвчлэн байгууллагын нууцад хамаарах мэдээллийг агуулдаг бөгөөд хэрэв тухайн мэдээлэл нь нийтэд ил болсон тохиолдолд зохицуулагч байгууллага хариуцлага хүлээж болно. Тиймээс, энэ асуудалд зохицуулагч байгууллагын байр суурь нь:

- Нууцлалыг чанд хадгалж, УУҮАТ болон уул уурхайн үйл ажиллагааны хөтөлбөрийг нийтэд ил болгохгүй байх;
- УУҮАТ-тэй холбогдох нууцлалыг хадгалах, гэхдээ урьдчилан оруулсан шалгуурыг нийтлэх; эсхүл
- УУҮАТ-г зохицуулагч байгууллагын бүс нутгийн албан газарт үзэх боломжтой баримт бичиг болгон хадгалах; эсхүл
- Худалдааны маш нууц мэдээллийг шаардаагүй эсхүл худалдааны маш нууц мэдээллийг (мөн мэдэгдэл гаргасан хүний хувийн мэдээллийг) хассан тохиолдолд УУҮАТ-г нийтэд ил болгохоос хамаарч өөр өөр байна.

Орлого, зарлагын мэдээллийг агуулсан жилийн тайлан (жилийн тайлан болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн буцаалтад хавсаргасан УУҮАТ эсхүл уул уурхайн хөтөлбөр зэрэг) нь ерөнхийдөө худалдааны маш нууц мэдээлэлд хамаарна гэж үздэг тулд олон нийтэд ил болгохгүй.

Дүгнэлт

Дүгнэн үзвэл, дараах онцлог зүйлүүд байна.

- 1) Зохицуулагч байгууллагад уул уурхайн төлөвлөсөн болон бодит үйл ажиллагааны мэдээллийг өгөхийн тулд Австралийн ихэнх муж улсуудад УУҮАТ эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ашигладаг. Эдгээрийг ерөнхийдөө (гэхдээ бүх улс оронд биш) зохицуулагч байгууллага техник эдийн засгийн үндэслэлийн оронд үйл ажиллагааны нийцлийг тодорхойлохын тулд ашиглагддаг.
- 2) УУҮАТ нь эхэндээ байгаль орчны нийцэлтэй холбоотой мэдээллийг өгөх, ялангуяа зохих төлөвлөлтийг хийлгэх, уурхайн хаалт болон уурхайн нөхөн сэргээлтийг хийлгэхэд шаардлагатай санхүүжилтийг бэлэн байлгахын тулд уул уурхайн үйл

ажиллагаа эрхлэгчид хангалттай үүрэг хүлээлгэх зорилгоор ашиглагддаг байсан хэдий ч, УУЯТ нь зохицуулагч байгууллага (уул уурхайн асуудал хариуцсан байцаагч хамаарна) болон төлөвлөлт хариуцсан төрийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны мэдээлэлд гол эх сурвалж болж байна.

- 3) Австрали болон Канадын нөхцөлд УУЯТ нь уул уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх буюу үргэлжлүүлэхэд шаардлагатай зөвшөөрлүүдийн зөвхөн нэг юм. Бусад гол зөвшөөрлүүд нь (а) ашиглалтын тусгай зөвшөөрөл, түүнд заасан нөхцөлийн хамт; (б) улсын болон/эсхүл Холбооны эрх бүхий байгууллагаас олгосон байгаль орчны зөвшөөрөл; (в) орон нутгийн захиргааны байгууллагаас олгосон бүтээн байгуулалтын зөвшөөрөл; (г) Барилга угсралт, төлөвлөгөө, гүйцэтгэл нь үндэсний болон улсын барилга байгууламж, цахилгаан техник, болон бусад дүрэм журамд нийцэж байгаа болохыг баталгаажуулсан гэрчилгээ; болон (д) төслийн тодорхой бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл (тэсэрч дэлбэрэх бодисын зөвшөөрөл, ус ашиглах тусгай зөвшөөрөл, хортой бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл гэх мэт) болно. Хэрэв УУЯТ шаарддаггүй бол зохицуулагч байгууллага нь ерөнхийдөө эдгээр бусад зөвшөөрлүүдээр дамжуулан үйл ажиллагааны нөхцөл шаардлагыг тогтоодог. Жишээлбэл орон нутгийн захиргааны байгууллага нь бүтээн байгуулалтын зөвшөөрлийг олгохоос өмнө салбарын боломжит стандартын талаар зохицуулагч байгууллагатай хамтран ажиллана.
- 4) УУЯТ-ыг батлах эсэх нь зохицуулагч байгууллагын үзэмж байдаг. Гэхдээ зохицуулагч байгууллагын тавьсан үйл ажиллагааны болон байгаль орчны шалгуурыг хангасан тохиолдолд зохицуулагч байгууллага нь УУЯТ-г батлахаас үндэслэлгүйгээр татгалзаж болохгүй. Тодорхой тохиолдлуудад зохицуулагч байгууллагаас бусад төрийн эрх бүхий байгууллагууд нийтийн ашиг сонирхлын үүднээс зөвшөөрлөө өгөхөөс татгалзаж болно.
- 5) УУЯТ нь 3-7 жилийн (улс орны болон үйл ажиллагааны байдлаас шалтгаалж) тодорхой хугацаатай байдаг. Гэсэн хэдий ч, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч нь батлагдсан УУЯТ-нд туссан мэдээллийг ноцтойгоор өөрчлөхийг хүсвэл, шинэчлэгдсэн УУЯТ-г батлуулахаар өгөх шаардлагатай.
- 6) Ихэнх улс орнуудад ямар загварыг ашигладаг вэ гэдгээс үл хамааран батлагдсан УУЯТ-ний нөхцөлийг дагаж мөрдөж байгаа эсэхээ зохицуулагч байгууллагад хүргүүлсэн жилийн тайланд тусгадаг. УУЯТ шаарддаггүй тодорхой улс орнуудад ашиглалтын тусгай зөвшөөрөлд заасан нөхцөлийг дагаж мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулахад жилийн тайланг ашигладаг байна.
- 7) Зохиогчийн үзэж байгаагаар, Монгол Улсын нөхцөл байдлыг харгалзан үзвэл (энэхүү судалгаанд байгаль орчны нөхцөлийг УУХҮЯ-д тайлагнах асуудлыг авч үзээгүй болно) УУЯТ-ний хамгийн тохиромжтой загвар нь Өмнөд Австрали болон Хойд нутаг дэвсгэрт ашигладаг загварууд байна. Эдгээр загварууд нь өргөдөл гаргагчаас ирүүлэх мэдээлэл, өгөгдлийг тодорхой зааж өгдөг бөгөөд мэдээлэл тусгасныг шалгах хуудсаар хураангуйлах, мөн салбартаа түгээх боломжтой байдаг. Мөн холбогдох мэдээллийг Монгол Улсын төрийн байгууллагын хэрэгцээнд тусгайлан нийцсэн байдлаар боловсруулж болно.

Australia Mongolia Extractives Program
2A Temple View Residence
Suhbaatar District-1
Ulaanbaatar
Mongolia
T: +976 7000 8595

www.amep.mn
/AMEP2 AusMonXtractives

